



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/630

Арвайхээр

Төсвийн зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 42 дугаар зүйлийн 42.2.1.а дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвөөс Халамжийн санд олгох санхүүжилтийн хэмнэлтээс 30,000,000 (гучин сая), Нөхөн сэргээх зардлын хэмнэлтээс 30,000,000 (гучин сая) төгрөг буюу нийт 60,000,000 (жаран сая) төгрөгийг Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн зардлыг нэмэгдүүлсүгэй.

2.Дээрх зардлын хуваарьт өөрчлөлт оруулж санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д, Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн зардлыг үр ашигтай, зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101384